



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүл томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 02, 03 дугаар хурлын шийдвэр, төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5, 10.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүлийг томилон, хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүлээр ажиллахад зарцуулах шатахууны зардлыг өдөрт 10.000 /арван мянга/ төгрөгөөр тооцон олгосугай.
3. Эргүүлээр ажилласан албан хаагчдын хоолны мөнгийг нэг хүний 10.000 /арван мянга/ төгрөгөөр тооцон хоолны зардлаас олгосугай.
4. Эргүүл хийсэн ажилтнуудын илүү цагийн хөлсийг журмын дагуу тооцон олгохыг нягтлан бодогч /Б.Энхдолгор/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА ЦЭРЭНДУЛАМ



318060155

МОНГОЛ

